72

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/45 Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (б) дэхь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогод сум орон нутгаас тусгах саналыг боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналыг удирдамжийн дагуу боловсруулан, хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын иргэдийн Төлөөлөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг Ажлын хэсэг, ахлагч (Д.Мөнхбат), батлагдсан санал болон сумын танилцуулгын мэдээллийг шинэчлэн www.sector.gov.mn вэб сайтад оруулахыг Нарийн бичгийн дарга (Т.Элбэгсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 089

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр Дугаар А/46 Хужирт сум

2019 оны төсвийн хуваарь батлах тухай

Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Өвөрхангай аймгийн Хужирт сумын 2019 оны төсөв батлах тухай” 10/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн байгууллагуудын төсвийн тодотгосон хуваарийг хавсралтаар батлалсугай.

2. Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч ( Л.Батбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 091

Сумын засаг даргын 20/19оны 4-р сарын 15-
ны өдрийн 1/42-р захирамжийн ......-р хавсралт

ЗДТГАЗРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН 2019 ОНЫ ХУВААРИЛАЛТ

| Эдийн Засгийн ангилал код | | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 80101 | 210101 | Үндсэн цалин | 153907.5 | 12825.6 | 12825.6 | 12825.6 | 12825.6 | 12825.6 | 12825.6 | 18825.6 | 6825.9 | 12825.6 | 12825.6 | 12825.6 | 12825.6 |
| | 210102 | Нэмэгдэл | 0.0 | | | | | | | | | | | | |
| | 210201 | НДШимтгэл | 19238.4 | 1603.2 | 1603.2 | 1603.2 | 1603.2 | 1603.2 | 1603.2 | 2353.2 | 853.2 | 1603.2 | 1603.2 | 1603.2 | 1603.2 |
| | 210301 | Гэрэл цахилгаан | 5465.8 | 600.0 | 600.0 | 600.0 | 600.0 | 400.0 | 200.0 | 120.0 | 120.0 | 120.0 | 700.0 | 700.0 | 705.8 |
| | 210302 | түлш халаалт | 29689.1 | 4240.7 | 4240.7 | 4240.7 | 4240.7 | 3188.8 | | | | 3185.8 | 0.0 | 3185.8 | 3165.9 |
| | 210303 | цэвэр бохир ус | 27.6 | 27.6 | | | | | | | | | | | |
| | 210401 | бичиг хэрэг | 3600.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 |
| | 210402 | тээвэр шатахуун | 14812.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 800.0 | 2400.0 | 0.0 | 1200.0 | 2012.0 |
| | 210403 | шуудан холбоо,интернет | 4400.0 | 732.0 | 732.0 | 0.0 | 0.0 | 366.0 | 366.0 | 366.0 | 366.0 | 370.4 | 361.6 | 146.5 | 593.5 |
| | 210404 | ном хэвлэл | 100.0 | 17.0 | 17.0 | 17.0 | | | 17.0 | | | 0.0 | 32.0 | 0.0 | 0.0 |
| | 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 500.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 42.0 | 32.0 | 52.0 | 42.0 | 38.0 |
| | 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 300.0 | 0.0 | | | 300.0 | | 0.0 | | | 0.0 | | | |
| | 210601 | багаж хэрэгсэл | 8850.0 | | 8850.0 | 0.0 | | | 0.0 | | | | | | |
| | 210602 | тавилга эд хогшил | 0.0 | | | | | | | | | | | | **0.0** |
| | 210604 | урсгал засвар | 3000.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 0.0 | 500.0 |
| | 210702 | дотоод албан томилолт | 6000.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 493.0 | 577.0 |
| | 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | 482.0 | | | 482.0 | | | 0.0 | | | | | | 0.0 |
| | 210802 | Аудит,баталгаажуулалт | 1040.0 | | | 1040.0 | | | 0.0 | | | | | | |
| | 210804 | т/хэрэгсэлийн татвар | 346.5 | | 0.0 | | 346.5 | | | | 0.0 | 0.0 | | | |
| | 210805 | т/хэрэгсэлийн оношлогоо | 110.0 | | 0.0 | | 110.0 | | | | 0.0 | 0.0 | | | |
| | 210807 | Газрын төлбөр | 2360.0 | | | 590.0 | | | 590.0 | | | 590.0 | | | 590.0 |
| | 210902 | хичээл үйлдвэрлэлийн дадлага | 150.0 | | 50.0 | | | 50.0 | 0.0 | | | 50.0 | | | |
| | **Дүн** | | 254378.9 | **22331.1** | **31203.5** | **23683.5** | **22311.0** | **20718.6** | **17886.8** | **23949.8** | **10050.1** | **22220.0** | **16617.4** | **20496.1** | **22911.0** |
| үйл ажиллагааны өөрийн орлого | | | 600.0 | | | **150.0** | | | **150.0** | | **150.0** | **0.0** | | **150.0** | **0.0** |
| 2018оны давсан орлогоос | | | 19813.5 | **7850.0** | **7850.0** | **4113.5** | | | | | | | | | |
| ОНОрлогоос | | | 151641.0 | **7600.0** | **9300.0** | **8750.0** | **11250.0** | **11320.0** | **13960.0** | **6100.0** | **5200.0** | **22220.0** | **15880.0** | **17150.0** | **22911.0** |
| санхүүгийн дэмжлэг | | | 82324.4 | **6881.1** | **14053.5** | **10670.0** | **11061.0** | **9398.6** | **3776.8** | **17849.8** | **4700.1** | **0.0** | **737.4** | **3196.1** | **0.0** |
| 80106 | 210101 | Үндсэн цалин | 57530.6 | 4794.2 | 4794.2 | 4794.2 | 4794.2 | 9588.4 | 4794.2 | 4794.2 | 7794.2 | 1794.4 | 4794.2 | 4794.2 | 0.0 |
| | 210201 | НДШимтгэл | 7191.3 | 599.3 | 599.3 | 599.3 | 599.3 | 1198.6 | 599.3 | 599.3 | 974.3 | 224.3 | 599.3 | 599.3 | 0.0 |
| | 210401 | бичиг хэрэг | 570.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 0.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 70.0 |
| | 210402 | тээвэр шатахуун | 1193.5 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 93.5 |
| | 210403 | шуудан холбоо,интернет | 400.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 33.0 | 37.0 |
| | 210404 | ном хэвлэл | 10.0 | | | | 10.0 | | | | | | | | |
| | 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл | 200.0 | 0.0 | 30.0 | 0.0 | 35.0 | 0.0 | 35.0 | 0.0 | 35.0 | 0.0 | 35.0 | | 30.0 |

75

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 30.0 | | | 30.0 | | | | | | | | | 0.0 |
| | 210601 | багаж техник хэрэгсэл | 100.0 | 20.0 | | 20.0 | | 20.0 | | 20.0 | | 20.0 | | | |
| | 210604 | урсгал засвар | 350.0 | 50.0 | | 50.0 | 0.0 | | 250.0 | 0.0 | 0.0 | 0.0 | | | 0.0 |
| | 210702 | дотоод албан томилолт | 771.4 | 116.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 58.0 | 75.4 |
| | 210801 | Бусад нийтлэг АҮТХураамж | 140.0 | | | | | 70.0 | | | | 70.0 | | | |
| | 210804 | т/ хэрэгсэлийн татвар | 40.0 | | | | 40.0 | | | | | 0.0 | | | |
| | 210805 | т/хэрэгсэлийн оношлогоо | 44.0 | | | | 44.0 | | | | | | | | |
| | 210902 | мэдээлэл суртчилгаа | | | | | | | 0.0 | | | | | | |
| | 210807 | Газрын төлбөр | 10.0 | | | | | 10.0 | | | | | | | |
| | Дүн | | 15.0 | | | | | 15.0 | | | | | | | |
| санхүүгийн дэмжлэг | | | 68595.8 | 5762.5 | 5664.5 | 5734.5 | 5763.5 | 11143.0 | 5919.5 | 5654.5 | 8994.5 | 2349.7 | 5669.5 | 5634.5 | 305.9 |
| 80305 | 210901 | биеийн тамир уралдаан тэмцээн | 68595.8 | 5762.5 | 5664.5 | 5734.5 | 5763.5 | 11143.0 | 5919.5 | 5654.5 | 8994.5 | 2349.7 | 5669.5 | 5634.5 | 305.9 |
| | Дүн | | 600.0 | 600.0 | | | 0.0 | | | | | | | | 0.0 |
| 2018оны давсан орлогоос | | | 600.0 | 600.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| санхүүгийн дэмжлэг | | | 300.0 | 300.0 | | | | | | | | | | | |
| 80802 | 213209 | нэг удаагийн тэтгэмж ур-л | 300.0 | 300.0 | | | | | | | | | | | |
| | Дүн | | 2000.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 200.0 |
| | | ОНОрлогоос | 2000.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 200.0 |
| 2018оны давсан орлогоос | | | 0.0 | | | | | | | | | 0.0 | | | 0.0 |
| 82801 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2000.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 200.0 | 150.0 | 200.0 |
| | Дүн | | 8000.0 | | | | | | 8000.0 | | | | | | |
| 2018 оны давсан орлогоос | | | 8000.0 | | | | | | 8000.0 | | | | | | |
| санхүүгийн дэмжлэг | | | 3000.0 | | | | | | 3000.0 | | | | | | |
| санхүүгийн дэмжлэг | | | 5000.0 | | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 5000.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 81102 | 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал/нөөц сан/ | 15000.0 | 2500.0 | 2500.0 | 1000.0 | 1000.0 | 800.0 | 1000.0 | 800.0 | 800.0 | 1200.0 | 1000.0 | 1200.0 | 1200.0 |
| | Дүн | | 15000.0 | 2500.0 | 2500.0 | 1000.0 | 1000.0 | 800.0 | 1000.0 | 800.0 | 800.0 | 1200.0 | 1000.0 | 1200.0 | 1200.0 |
| санхүүгийн дэмжлэг | | | 15000.0 | 2500.0 | 2500.0 | 1000.0 | 1000.0 | 800.0 | 1000.0 | 800.0 | 800.0 | 1200.0 | 1000.0 | 1200.0 | 1200.0 |
| 82207 | 210901 | Хот байгуулалт тохижолт | 59233.1 | 10436.5 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 3796.6 |
| | Дүн | | 59233.1 | 10436.5 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 3796.6 |
| санхүүгийн дэмжлэг | | | 53296.6 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 4500.0 | 3796.6 |
| 2018оны давсан орлогоос | | | 5936.5 | 5936.5 | | | | | | | | | | | |
| | Нийт дүн | | 407807.9 | 41780.1 | 44018.0 | 35118.0 | 33574.5 | 37311.6 | 37506.3 | 35054.3 | 24494.6 | 30569.7 | 27986.9 | 31980.6 | 28413.5 |
| | 350002 | Өөрийн орлого | 600.0 | 0.0 | 0.0 | 150.0 | 0.0 | 0.0 | 150.0 | 0.0 | 150.0 | 0.0 | 0.0 | 150.0 | 0.0 |
| | 320001 | санхүүгийн дэмжлэг/ОНО-с/ | 151991.0 | 7600.0 | 9300.0 | 8750.0 | 11250.0 | 11320.0 | 13960.0 | 6100.0 | 5200.0 | 22370.0 | 15880.0 | 17150.0 | 23111.0 |
| | 320001 | аймгийн санхүүжилтээр | 225666.9 | 19943.6 | 26718.0 | 21904.5 | 22324.5 | 25991.6 | 20396.3 | 28954.3 | 19144.6 | 8199.7 | 12106.9 | 14680.6 | 5302.5 |
| | 350003 | 2018оны давсан орлогоос | 29550.0 | 14236.5 | 8000.0 | 4313.5 | 0.0 | 0.0 | 3000.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | | | 407807.9 | 41780.1 | 44018.0 | 35118.0 | 33574.5 | 37311.6 | 37506.3 | 35054.3 | 24494.6 | 30569.7 | 27986.9 | 31980.6 | 28413.5 |

77

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/47 Хужирт сум

Зээл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сан"-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт, "Сум хөгжүүлэх сан"-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ нь:

1. Сум хөгжүүлэх сангаас 2017-2018 онд олгогдсон зээлийн эргэн төлөлтөөс төвлөрсөн хөрөнгөөс 93000000 (ерэн гурван сая) төгрөгийг 21 төсөлд зээл олгосугай.

2. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан 21 төсөл, төсөл хэрэгжүүлэх иргэн, аж ахуй нэгжийн нэрс, олгох зээлийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Дээрх төсөлд олгогдох 93000000 (ерэн гурван сая) төгрөгийг Сум хөгжүүлэх сангийн данснаас олгон, орлого зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж дүнг танилцуулж байхыг Санхүүгийн албаны дарга (Л.Батбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2591 093

Засаг даргын 2019 оны 04-р сарын ..19..... –ны
өдрийн А/47-р захирамжийн хавсралт

**“Сум хөгжүүлэх сан”-гийн төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан иргэд, аж ахуй нэгжийн нэрс, олгох зээлийн хэмжээ**

| № | Иргэн , аж ахай нэгж байгууллагын нэр | Холбоо барих утас | Үйл ажиллагааны чиглэл | Хүссэн санхүүжилт сая.төг | Шийдвэрлэсэн санхүүжилтийн хэмжээ сая.төг | Зээлийн нөхцөл | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хугацаа /сар/ | Хүүгийн хэмжээ /%/ | Алданги /хугацаа хэтрүүлсэн хоног тутам/ % |
| 1 | Ю.Сарантуяа | 91819303 | Оёдол, гар урлал | 10,0 | 2,5 | 36 | 3 | 0,3 |
| 2 | Ч.Бат-Өлзий | 99593401 | Гэрийн мод сийлбэр тавилга | 10,0 | 8,0 | 36 | 3 | 0,3 |
| 3 | Ч.Найдандорж | 88302969 | Нэхий элдэх бага оврын үйлдвэрлэл | 10,0 | 10,0 | 36 | 3 | 0,3 |
| 4 | Н.Уранжаргал | 88408816 | Нийтийн хоолны үйлдвэрлэл | 10,0 | 2,5 | 36 | 3 | 0,3 |
| 5 | Ч.Нарангэрэл | 89297880 | Монгол гоёл | 10,0 | 5,0 | 36 | 3 | 0,3 |
| 6 | А.Батчимэг | 88325207 | Үсчин гоо сайхан | 5,0 | 1,0 | 36 | 3 | 0,3 |
| 7 | Д.Санжидмаа | 99951711 | Сүү цагаан идээ мах | 10,0 | 3,0 | 36 | 3 | 0,3 |
| 8 | Н.Санжидмаа | 88309564 | Сүү цагаан идээ | 12,0 | 1,0 | 36 | 3 | 0,3 |
| 9 | Т.Пүрэвсүрэн | 88996798 | Модон эдлэл | 10,0 | 2,0 | 36 | 3 | 0,3 |
| 10 | У.Мөнхбат | 89401670 | “Од” ресторан | 15,0 | 10,0 | 36 | 3 | 0,3 |
| 11 | Ц.Мягмар-Очир | 88847280 | Гэрийн мод | 6,0 | 5,0 | 36 | 3 | 0,3 |
| 12 | Ж.Баярсайхан | 89400413 | Хоёр дахь түүхий эд | 17,0 | 10,0 | 36 | 3 | 0,3 |
| 13 | Ю.Эрдэнэбилэг | 89523133 86430060 | Taxi үйлчилгээ | 11,0 | 5,0 | 36 | 3 | 0,3 |
| 14 | С.Нямхүү | 99024939 | Компьютер үйлчилгээ | 4,0 | 2,0 | 36 | 3 | 0,3 |

78

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Мөнх Ундарга Тур ХХК | 88109511 | Тэжээлийн ургамал тариалах | 10,0 | 10,0 | 36 | 3 | 0,3 |
| 16 | Ш.Отгонмаа | 89199109 | Үсчин | 5,0 | 4,0 | 36 | 3 | 0,3 |
| 17 | П.Болормаа | 88269019 | Өег хэрчсэн гурил үйлдвэрлэх | 6,0 | 1,0 | 36 | 3 | 0,3 |
| 18 | Ч.Баянмөнх | 88185912 | Зоогийн газар | 10,0 | 2,5 | 36 | 3 | 0,3 |
| 19 | С.Намжилдагва | 89112764 | Сүү сүүн бүтээгдэхүүн | 4,4 | 1,0 | 36 | 3 | 0,3 |
| 20 | Ч.Цэцэгмаа | 89367377<br>99967087<br>89244013 | Хужирт оёдол | 10,0 | 2,5 | 36 | 3 | 0,3 |
| 21 | Д.Пүрэвжал | 96363747 | Авто угаалгын газар | 10,0 | 5,0 | 36 | 3 | 0,3 |
| Нийт | | | - | 195,4 | 93,0 | - | - | - |

96

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/48 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Социологийн судалгаа зохион байгуулах хамтын ажиллагааны гэрээний гүйцэтгэлд 500000 (таван зуун мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2019 оны 04 дугаар
сарын 29–ны өдрийн
А/48 дугаар захирамжийн хавсралт

Төслийн судалгааны хавсралт

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Төслийн судалгаа | 1 | 500000 | 500000 |
| | | | | **500.000** |

-оОо-

82

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/49 Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 3 дугаар багийн "Бэрх багийн төвийн байрны засвар ӨВХУСЗДТГ/201901014" ажлын гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Д.Энхтүвшин | Засаг даргын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Гишүүд: | Д.Мөнхбат | Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| | Л.Цэдэв | Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Ц.Нямдорж | Газрын даамал |
| | Б.Пүрэвжав | Төсөв,Төрийн сангийн мэргэжилтэн |

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 097

83

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/50 Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Хужирт сумын Засаг даргын Тамгын газарт "Дугуйт ачигч ковш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВХУСЗДТГ/201901009" тендерт шаардлага хангасан тендер ирээгүй тул хүчингүй болгосугай.

2. Дээрх тендерийг холбогдох хуулийн дагуу дахин нээлттэй тендер шалгаруулалтын журмаар явуулахыг Үнэлгээний хорооны дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 099

84

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 25 өдөр Дугаар А/51 Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2005 оны 122 дугаар захирамжийн 19, 2008 оны 4 дүгээр захирамжийн хавсралтын 43 дугаарт байгаа 2 өрхийн нэр бүхий 7 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 101

Хужирт сумын Засаг даргын 2019 оны
4 дугаар сарын 25 -ны өдрийн А/51 дугаар
захирамжийн хавсралт

Газар өмчлөх эрхээ шилжүүлсэн иргэдийн нэрсийн жагсаалт

| өрхийн дугаар | Д/д | Өмчлөгчийн | | | | | | Урьд нь газар өмчлүүлсэн захирамжийн дугаар, огноо | Газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Оршин суугаа хаяг | Регистр | 16 нас хүрээгүй өмчлөгчийн гэрчилгээний дугаар | | Байршил | Хэмжээ /м2/ | Газрын үнэ /мян.төг/ |
| А | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 19 | 1 | Угтаал | Цэрэндүг | Жаргал | 5-р баг | ЙС73012005 | | 2005.12.01 122 | 5-р баг Гуа 14-5 тоот | 1145 | 824400 |
| | 2 | Сант боржигин | Жаргалсайхан | Цэвэлмаа | 5-р баг | ЙС96102808 | | | | | |
| | 3 | Сант боржигин | Жаргалсайхан | Цэвэлдорж | 5-р баг | ЙС98112812 | | | | | |
| | 4 | Сант боржигин | Жаргалсайхан | Цэрэндорж | 5-р баг | ЙС00302331 | | | | | |
| 43 | 5 | Омбо | Санжаа | Дуламжав | 4-р баг | ЙС79081809 | | 2006.06.09 60 | 4-р баг Шивээт 7-3 тоот | 1648 | 1186560 |

85

86

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 25 өдөр | Дугаар А/52 | Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан Ж.Отгонд хүндэтгэл үзүүлэхэд 105000 (нэг зуун таван мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 103

Сумын Засаг даргын 2019 оны 04 дугаар
сарын 25 –ны өдрийн
А/152 дугаар захирамжийн хавсралт

Үндсэн хууль баталсан өдөрт

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Номын багц | 1 | 105000 | 105000 |
| | | | | **105.000** |

-оOо-

88

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 25 өдөр | Дугаар А/53 | Хужирт сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Тохижиолт- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай" 09/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2019 оныг "Тохижилт - Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан сумын зорилтот жилийн нээлтийн арга хэмжээний зардалд 628000 (зургаан зуун хорин найман мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 105

89

Сумын Засаг даргын 2019 оны 04 дугаар
сарын 05 –ны өдрийн
А/33 дугаар захирамжийн хавсралт

Тохижилтын хавсралт

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Тохижилт | 1 | 62800 | 62800 |
| | | | | **62.800** |

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 05 өдөр Дугаар А/57 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор сумын байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулагддаг спортын арга хэмжээний шагналын зардалд 200000 (хоёр зуун мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

91

Сумын Засаг даргын 20 19 оны 04 дугаар
сарын 05-ны өдрийн
А/54 дугаар захирамжийн хавсралт

Нийтийн биеийн тамирын спортын зардалд

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Медаль, өргөмжлөл | 1 | 200000 | 200000 |
| | | | | **200.000** |

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 25 өдөр    Дугаар А/55    Хужирт сум

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх “Бэрх 3 дугаар багийн төвийн байрны засвар”-ын ажлын явцад хяналт тавих, хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Д.Энхтүвшин | Засаг даргын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Гишүүд: | Д.Мөнхбат | Засаг даргын Тамгын газрын дарга |
| | Л.Цэдэв | Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | Б.Пүрэвжав | Төсөв,Төрийн сангийн мэргэжилтэн |
| | М.Чимэдрэгзэн | Нярав |

2. Дээрх ажлын явц, чанарт хяналт тавьж, гэрээний дагуу хүлээж авахыг ажлын хэсэгт, явцын талаар Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    Т.БАЯРМӨНХ

2521 119

93

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 25 өдөр Дугаар А/56 Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 1 дүгээр зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн төвийн "Түргэн тусламжийн автомашинд шатахуун нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201901001" тендерийг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 112

94

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/57 Хужирт сум

Хүүхэд үрчлүүлэх тухай

Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 55.7, 55.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн иргэн Гантөмөрийн Бүүвэйбаатар (ЙС85050419), Түвдэнгийн Нарангарав (ЙС83060700) хүсэлтийн дагуу тэдний хүү Бүүвэйбаатарын Очиртөгөлдөрийг (йс03232017) Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5 дугаар баг Шунхлай хаягт оршин суугч нөхөр Баянжаргалын Доржпагам (ЙС79121117), эхнэр Түвдэнгийн Нарангарав (ЙС83060700) нарт үрчлүүлсүгэй.

2. Баримт бичгийг бүрдэл болгож гэрчилгээ олгохыг Улсын бүртгэгч (Ш.Дэлгэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 113

95

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 30 өдөр Дугаар А/58 Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн иргэн Ж.Шижээ (ЙС75040839) нь өөрийн эзэмшлийн 2 дугаар багийн нутаг Жамбалын талд байрлах 000004874 тоот гэрчилгээний дугаартай, 6211003827 тоот нэгж талбарын дугаартай үр тарианы усалгаатай тариалангийн зориулалттай 4650000.0 м2 газрыг Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо 12 дугаар хороолол, 52 дугаар байрны 37 тоот хаягт оршин суугч Л.Ариунбатын (ЛЖ67102015) эзэмшилд шилжүүлсэн тул дээрх газрыг Л.Ариунбат (ЛЖ67102015)-д үр тарианы усалгаатай тариалангийн зориулалтаар 29 жил 11 сарын хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" А/168 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2591 115

96

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 30 өдөр | Дугаар А/59 | Хужирт сум

Хүүхэд үрчлүүлэх тухай

Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 55.7, 55.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн иргэн Гантөмөрийн Бүүвэйбаатар (ЙС85050419), Түвдэнгийн Нарангарав (ЙС83060700) хүсэлтийн дагуу тэдний охин Бүүвэйбаатарын Ариунтуулыг (ЙС07211808) Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5 дугаар баг Шунхлай хаягт оршин суугч нөхөр Баянжаргалын Доржпагам (ЙС79121117), эхнэр Түвдэнгийн Нарангарав (ЙС83060700) нарт үрчлүүлсүгэй.

2. Баримт бичгийг бүрдэл болгож гэрчилгээ олгохыг Улсын бүртгэгч (Ш.Дэлгэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 117

97

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 02 өдөр Дугаар А/60 Хужирт сум

Хүүхэд үрчлүүлэх тухай

Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 55.7, 55.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 3 дугаар багийн иргэн Гэрэлийн Очирпүрэв (ЙС97031310), Гадиймаагийн Лхагвамаа (ЙС97040921) нарын хүсэлтийн дагуу тэдний хүү Очирпүрэв Эрдэнэзаяаг (ЙС17270233) Өвөрхангай аймгийн Хужирт сумын 5 дугаар баг Шунхлай хаягт оршин суугч өвөө Нэргүйн Гадиймаа (ЙЮ74051773), эмээ Мягмарын Мандахбаяр (ЙС74081305) нарт үрчлүүлсүгэй.

2. Баримт бичгийг бүрдэл болгож гэрчилгээ олгохыг Улсын бүртгэгч (Ш.Дэлгэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 119

98

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/61 Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Л.Цэдэв | Төрийн захиргааны мэргэжилтэн |
| Дуудлага худалдааны хөтлөгч: | Ц.Нямдорж | Газрын даамал |
| Тэмдэглэл хөтлөгч: | О.Алтанчимэг | Байгаль хамгаалагч |

2. Ажлын хэсгийн ахлагч (Л.Цэдэв)-т ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн доод хязгаарыг Эрүүл мэндийн үйлчилгээний зориулалттай 0,07 га газарт 560 000 (таван зуун жаран мянган төгрөг) байхаар, Үүрэн холбооны антенн, тоног төхөөрөмж байршуулах зориулалттай 0,01 га газарт 80 000 (наян мянган төгрөг) байхаар тус тус тогтоон, зохих журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах;

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15,1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах;

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 121

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/62 Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай хөтөлбөрт хүнсний материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201901006/2" тендерийг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

/150

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/63 Хужирт сум

Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 2 дугаар зөвлөмжийн дагуу "1 дүгээр Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201901004/2" тендерийг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтанд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулж ажиллахыг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч (З.Оюунчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 128

101

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 06 өдөр Дугаар А/64 Хужирт сум

## Тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу “2 дугаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ201901006/2” тендерийн 2, 3 дугаар багцыг хүчингүй болгосугай.

2. Тендер шалгаруулалтын дээрх багцад нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахыг 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч (Ш.Эрдэнэхорол)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 127

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр Дугаар А/65 Хужирт сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дулаан 6 дугаар багийн нутаг дэвсгэр "Асгатын энгэр" гэх газар нутаглаж байгаа малчин С.Балдандоржийн 1 нохойнд мал, амьтны халдварт галзуу өвчний шинж тэмдэг илэрч Мал эмнэлгийн тасгийн 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 1 дүгээр саналаар 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа 6 хот айлын 16 өрхийн 2527 бог мал, 383 бод малыг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг, галзуу нохойд хазуулсан иргэнд эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай үзүүлэхийг, "Гуахарз" мал эмнэлгийн малын их эмч (Ц.Батдэлгэр), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Э.Баасансүрэн), 6 дугаар багийн Засаг дарга (Ц.Амгалан) нарт тус тус даалгасугай .

3. Холбогдох заавар журмын дагуу хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат), уг захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа), Цагдаагийн тасгийн хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Э.Бямбацэрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

102

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр Дугаар А/66 Хужирт сум

## Мал эмнэлгийн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг технологит хугацаанд нь зохион байгуулсугай.

2. Вакцинжуулалтын ажлыг чанартай, үр дүнтэй гүйцэтгэхийг “Гонир манал”, “Гуахарз” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Ш.Байгальмаа), (Ц.Батдэлгэр) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тарилгын акт жагсаалтад дүгнэлт гарган тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 131

104

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 13 өдөр Дугаар А/67 Хужирт сум

Мал эмнэлэг, ариун цэврийн сарын аян
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а” дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд “Мал эмнэлэг, ариун цэвэр”-ийн сарын аяныг 5 дугаар сарын 13-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулсугай.

2. Сарын аяны ажлын төлөвлөгөөг боловсруулан “Гуа харз”, “Гонир манал” мал эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 133

105

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 17 өдөр Дугаар А/68 Хужирт сум

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар байгуулсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай” 101 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 136

Сумын Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 14 –ны өдрийн А/62 дугаар захирамжийн хавсралт

## Засаг даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга: Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: Засаг даргын орлогч

- Засаг даргын Тамгын газрын дарга
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга
- Санхүүгийн албаны дарга
- Багийн Засаг дарга
- Нийгмийн халамжийн сум хариуцсан мэргэжилтэн
- Нягтлан бодогч
- Ерөнхий боловсролын сургуулийн захирал
- Эрүүл мэндийн төвийн дарга

-оОо-

102

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 14 өдөр Дугаар А/69 Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу Хужирт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны хүнсний материал нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ӨВАХУСЗДТГ201901007” тендерийг 75003200 (далан таван сая гурван мянга хоёр зуун) төгрөгөөр “Дэлгэрэх Хужирт” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 137

108

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/70 Хужирт сум

## Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 11.4 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн нутаг Эрүүл мэндийн төвийн урд байрлах 0,07 га газрыг Улаанбаатар хотын харьяат Цэрэнжамцын Отгонд (ЙС83041915) эрүүл мэндийн үйлчилгээ эрхлэх зориулалтаар (30 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д даалгасугай.

3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг иргэн (Ц.Отгон)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 139

107

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/71 Хужирт сум

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах,
техникийн хяналтын үзлэг явуулах,
жолоочийн даатгалд хамруулах тухай

Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, $19^1$ дүгээр зүйлийн $19^1$.1 дэх заалт, Аймгийн засаг даргын 2019 оны “Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, Техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах тухай” А/131 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд тээврийн хэрэгслийн 2019 оны техникийн хяналтын үзлэг явуулах ажлын бэлтгэлийг хангуулах, зохион байгуулах салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын ахлагч: | Д.Энхтүвшин | Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Б.Цэрэннадмид | Татварын улсын байцаагч |
| Гишүүд: | Х.Түмэнбаяр | Цагдаагийн тасгийн дарга |
| | Э.Бямбацэрэн | Хэсгийн төлөөлөгч |
| | Ц.Базарваань | Хэв журмын цагдаа |
| | Т.Даваадорж | 1 дүгээр багийн Засаг дарга |
| | Д.Батбаян | 2 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Галиндэв | 3 дугаар багийн Засаг дарга |
| | Д.Батбаяр | 4 дүгээр багийн Засаг дарга |
| | Ц.Лхамролом | 5 дугаар багийн Засаг дарга |
| | Ц.Амгалан | 6 дугаар багийн Засаг дарга |

2. Авто техникийн үзлэгийг 2019 оны 5 дугаар сарын 24-ны өдрөөс 5 дугаар сарын 29-ны өдөр хүртэлх хугацаанд тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжийг бүрэн хамруулж ажиллахыг Комиссын ахлагч (Д.Энхтүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 141

110

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/72 Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу Хужирт сумын зорилтот бүлгийн иргэдэд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах тендерийг 128736000 (нэг зуун хорин найман сая долоон зуун гучин зургаан мянган) төгрөгөөр “Хужирт нутаг” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн халамжийн ажилтан (Ё.Даариймаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2591 143

111

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/73 Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн хүсэлтийг харгалзан 2019 оны 1-4 дүгээр сарын байрны түрээсийн төлбөрт 300000 (гурван зуун мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 145

112

Сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар
сарын 20 –ны өдрийн
А/13 дугаар захирамжийн хавсралт

Түрээсийн төлбөр

| № | Зардлын төрөл | Нэгжийн тоо | Нэгж ноогдох мөнгөн дүн | Нийт мөнгөн дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Түрээсийн төлбөр | 4 | 75000 | 300000 |
| | | | | **300.000** |

-оОо-

113

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/74 Хужирт сум

## Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны төслийн ажлын хэсэг сумын цэвэр усны нөөцийг судлах ажлаар ирж ажилласантай холбогдуулан нэг удаагийн хоолны зардалд 150000 (нэг зуун тавин мянган) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 147

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/75 Хужирт сум

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын уугуул төр нийгмийн зүтгэлтэн, Монгол Улсын Их хурлын дэд дарга, Улсын Их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн асан Гаваагийн Батхүү нь зуурдаар таалал төгссөн тул 100000 (нэг зуун мянган) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 149

116

# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/76 Хужирт сум

**Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх салбар комисс байгуулах, ажлын төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засгийн 2019 оны "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 150 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө батлах, салбар комиссын бүрэлдэхүүн батлах тухай" А/323 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх байгууллагын салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын төлөлвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллага бүр үзлэгт бэлтгэх комисс томилон үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг салбар комисст, төлөвлөгөөний биелэлтийн талаар 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор танилцуулахыг комиссын дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 151

Сумын Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 20 –ны өдрийн А/26 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Улсын үзлэгт бэлтгэх салбар комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга: Д.Мөнхбат -Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Т.Элбэгсайхан -Архив, бичиг хэргийн эрхлэгч

Гишүүд: Л.Цэдэв -Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Пүрэвжав -Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Ц.Нямдорж -Газрын даамал

Б.Самдан - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технилоги, үржил бүртгэл, бэлчээрийн менежмент, усан хангамж хариуцсан мэргэжилтэн

Б.Доржсэмбэ -Газар тариалан, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн

М.Чимэдрэгзэн -Нярав

О.Алтанчимэг –Байгаль хамгаалагч

-оОо-

Сумын Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 20 –ны өдрийн А/76 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГТ БЭЛТГЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2019.05.24 Хужирт сум

| № | Хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр | | | |
| 1 | Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 5 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын удирдлага |
| 2 | Байгууллагын дарга, эрхлэгч, архив бичиг хэргийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, зөвлөмж чиглэл өгөх | 5 дугаар сард | Сумын салбар комисс |
| 3 | Төсөвт байгууллагуудад урьдчилан үзлэг хийж, дүн гаргах | 6 дугаар сард | ЗДТГазар |
| Хоёр. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт | | | |
| 1 | Байгууллагын стратегийн төлөвлөгөө, /гүйцэтгэлийн төлөвлөгөө/ дотоод дүрэм, журмыг боловсронгуй болгох | 6,7 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, байгууллагын удирдлага |
| 2 | 2015 оны улсын үзлэгийн мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө, биелэлт гаргах | 5 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 3 | Албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулж дүгнэх болон ажлын байрны тодорхойлолтыг нэгжүүдийн зорилт чиг үүрэгтэй уялдуулах | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 4 | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбрийг хэрэгжүүлэх | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 5 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах | 6 дугаар сард | Байгууллагын удирдлагууд |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | "Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | 5 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| | Гурав.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа | | |
| 1 | Албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан заалтыг шинэчлэх | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 2 | Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтны нийгмийн баталгаар хангах арга хэмжээ боловсруулах | 5 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 3 | Албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах талаар хэтийн төлөвлөгөө, гэрээнд тусгах | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга |
| 4 | Захиргааны актуудад хувийн хэрэг хөтөлж бүрдүүлэх | 5 дугаар сард | Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн, байгууллагын удирдлагууд |
| 5 | Байгууллагаас боловсруулж буй захирамжлалын баримт бичиг болон бусад албан бичгийн зөв бичих дүрэм, найруулга зүйн, албан бичгийн стандарт хангах, хяналт тавих | 6 дугаар сард | Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгууллагын удирдлагууд |
| 6 | Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр болон бусад бичгийн бүртгэл, шийдвэрлэлтэнд хяналт тавих | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын удирдлага |
| | Дөрөв. Архивын үйл ажиллагаа | | |
| 1 | Архивын өрөөний тоног төхөөрөмж, тохижилт стандартыг хангах | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын удирдлага |
| 2 | Архиын шүүгээ, ном тохимол, хууль тогтоомжийн эмхтгэлээр хангах | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын удирдлага |
| 3 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үнэн зөв гаргасан болон албан хаагчид жагсаалтын дагуу архивт шилжүүлсэн эсэхэд хяналт тавих | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын удирдлага |
| 4 | Архивын тухай хуулийн дагуу төрийн архивт баримтаа шилжүүлэх | 6 дугаар сард | Албан хаагчид |
| 5 | Архивын баримтыг зааврын дагуу эмхлэн цэгцэлж, хадгаламжийн нэгж бүрдүүлэх | 6 дугаар сард | Архивын ажилтан |
| 6 | Архивын баримт бичгийг зааврын дагуу хөтөлж, бүртгэл, хөдөлгөөнийг тэмдэглэх | 6 дугаар сард | Архивын ажилтан |
| 7 | ББНШКомиссын үйл ажиллагааг тогтмолжуулах | 6 дугаар сард | Архивын ажилтан |
| | Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх | | |

119

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэхэд шаардагдах зардлын эх үүсвэрийг шийдэх | 6 дугаар сард | Засаг даргын Тамгын газрын дарга, Байгууллагын удирдлагууд |
| 2 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд программ хангамж нэвтрүүлэх, ашиглах | Тухай бүр | Байгууллагын удирдлагууд Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан |
| 3 | Сүлжээ, сервер, компьютеруудын аюулгүй байдал, найвдартай ажиллагааг хангах | 5 дугаар сард | Байгууллагын удирдлагууд |
| 4 | Цахим мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах | 6 дугаар сард | Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан |
| 5 | Үндэсний хөтөлбөрийн IV үе шатны зорилтыг хэрэгжүүлэх хэтийн ба ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг тайлагнах | 6 дугаар сард | Байгууллагын удирдлагууд Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтан |
| 6 | Албан хаагчдын цахим санг баяжуулах | 6 дугаар сард | Байгууллагын удирдлага, Албан хаагчид |

-оОо-

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 22 өдөр Дугаар А/77 Хужирт сум

Хагас жилийн малын түүвэр судалгаа авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 (г), Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 (в) дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2019 оны хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Энхтүвшин -Засаг даргын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвжав -Төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд: С.Самдан - Мал аж ахуй үйлдвэрлэлийн технилоги, үржил бүртгэл, бэлчээрийн менежмент, усан хангамж хариуцсан мэргэжилтэн
Т.Даваадорж -1 дүгээр багийн Засаг дарга
Д.Батбаян -2 дугаар багийн Засаг дарга
Д.Галиндэв - 3 дугаар багийн засаг дарга
Д.Батбаяр - 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом - 5 дугаар багийн Засаг дарга
Ц.Амгалан - 6 дугаар багийн Засаг дарга

2. Хагас жилийн малын түүвэр судалгааны ажлыг батлагдсан удирдамж, графикийн дагуу 2019 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтүвшин), нэгдсэн дүн мэдээг 6 дугаар сарын 14-ний дотор холбогдох газарт хүргүүлэхийг Нарийн бичгийн дарга (Б.Пүрэвжав) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 153

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

# ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 22 өдөр Дугаар А/78 Хужирт сум

## Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Мал амьтны, эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Дулаан 6 дугаар багийн нутаг Асгатын энгэр гэдэг газарт нутаглаж буй тус багийн малчин С.Балдандоржийн хотонд хязгаарлалтын дэглэмийн хугацаанд галзуу өвчний шинж тэмдэг шинээр илрээгүй тул 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/65 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэм цуцалсан нутаг дэвсгэрийн хил залгаа байгаа мал амьтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 155

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 27 өдөр Дугаар А/79 Хужирт сум

Газар ашиглах эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 11.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 5 дугаар багийн нутаг Соёмбот талбайн зүүн хойд талд байрлах 0,01 га газрыг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж 47 тоотод байрлах "Мобиком корпораци" ХХК-д (2072572) Үүрэн холбооны антенн, тоног төхөөрөмж байршуулах зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д даалгасугай.

3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг "Мобиком корпораци" ХХК-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 157

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/80 Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 30 дугээр зүйлийн 30.1, 52 дугаар зүйлийн 52,7 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтанд дурьдсан нэр бүхий 5 иргэнд өвөлжөө хаваржааны доорхи газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 159

Хужирт сумын Засаг даргын 2019 оны
05 дугээр сарын 29 -ний өдрийн А/80 тоот
захирамжийн хавсралт

Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг шинээр эзэмших иргэдийн нэрсийн жагсаалт

| д/д | Газар эзэмшигчийн | | | Эзэмшсэн газрын | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эцэг /эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистрийн дугаар | Багийн нэр, дугаар | Хаяг, байршил, газар зүйн нэр | Зориулалт | Хэмжээ /м²/ | Газар зүйн солбицол |
| 1 | Борис | Гомбосүрэн | Йс84033014 | Ужим 2-р баг | Гурван давааны өвөр мухар мод | Өвөлжөө | 700 | $102^{0}32^{1}7.466$ $46^{0}45^{1}17.076$ |
| 2 | Өлзийдүүрэн | Цэрэнбат | Йс82021818 | Ужим 2-р баг | Гурван давааны ар | Өвөлжөө | 700 | $102^{0}30^{1}28.834$ $46^{0}45^{1}37.932$ |
| 3 | Ганболд | Дэлгэрсайхан | Йс01242811 | Бэрх 3-р баг | Мойлтын ногоон бургастын энгэрийн бууц | Өвөлжөө | 700 | $102^{0}44^{1}19.7$ $47^{0}1^{1}5.541$ |
| 4 | Болоож | Санжаасүрэн | Йс75052034 | Бэрх 3-р баг | Хуурамчийн хөтөл | Хаваржаа | 700 | $102^{0}38^{1}29.211$ $46^{0}57^{1}20.398$ |
| 5 | Болоож | Санжаасүрэн | Йс75052034 | Бэрх 3-р баг | Хар сайрт | Хаваржаа | 700 | $102^{0}39^{1}16.576$ $46^{0}57^{1}23.436$ |

126

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 29 өдөр          Дугаар А/81          Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж байгуулах ӨВХУСЗДТГ/201901010" ажлын гүйцэтгэгчийг сонгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтүвшин - Засаг даргын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: З.Цэцэгмаа - Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
Ж.Шижээ - "Хужирт Эрдэс баялаг" ОНӨААТҮГазрын дарга
О.Алтанчимэг - Байгаль хамгаалагч
Ч.Сонинбаяр – Байгаль хамгаалагч

2. Гэрээ шууд байгуулах ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний төслийг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Энхтүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА          Т.БАЯРМӨНХ

2521 161

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/82 Хужирт сум

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1, 67 дугаар зүйлийн 67.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 3 дугаар багийн иргэн Дашдуламын Болортуяагийн (ЙС03250203) харгалзан дэмжигчээр түүний нагац эгч Даваадавгын Бат-Эрдэнийг (ЙС79071049) тогтоосугай.

2. Холбогдох баримт бичгийг бүрдэл болгож тэтгэмжинд хамруулахыг Нийгмийн халамжийн ажилтан (Ё.Даариймаа), Нийгмийн даатгалын тасгийн дарга (Ч.Байгальмаа), асран хамгаалах үүрэгт хяналт тавьж ажиллахыг 3 дугаар багийн Засаг дарга (Д.Галиндэв) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2501 163

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 07 өдөр Дугаар А/83 Хужирт сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу Ерөнхий боловсролын сургуулийн анги, танхимд уян камер, телевизор, камер нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 18280000 (арван найман сая хоёр зуун наян мянган) төгрөгөөр “Отгоннинж” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Дээрх шалгарсан компанитай гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг орлон гүйцэтгэгч (А.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 11 өдөр Дугаар А/84 Хужирт сум

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

"Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Засаг даргын 2016 оны "Газар өмчлүүлэх тухай" 17 дугаар захирамжийн хавсралтын 55 дугаарт байгаа 1 өрхийн нэр бүхий 5 иргэний өөрсдийн гаргасан хүсэлт, газар өмчлөх эрх шилжүүлэх гэрээг үндэслэн хавсралтанд заасан нэр бүхий иргэдийн газар өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2. Газрыг тухайн гэр бүлийн аль нэг гишүүнд өмчлүүлж, бусад гишүүдэд газрыг хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа үнэгүй өмчлүүлэх ажлыг зохион байгуулахыг газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Т.БАЯРМӨНХ

2521 167